



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТУУЛ ГОЛЫН САВ ГАЗРЫН ЗАХИРГААНЫ 2021 ОНЫ САНХҮҮГИЙН  
ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/02/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх  
аудитор Ц.Наранчимэг  
Утас: 261663 Цахим хаяг: [naranchimegts@audit.gov.mn](mailto:naranchimegts@audit.gov.mn)  
Аудитын менежер: Г.Гүнжидмаа  
Утас: 261628 Цахим хаяг: [gunjidmaag@audit.gov.mn](mailto:gunjidmaag@audit.gov.mn)  
Аудитор: Г.Мөнхчимэг  
Утас: 260512 Цахим хаяг: [munkhchimegg@aaudit.gov.mn](mailto:munkhchimegg@aaudit.gov.mn)  
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Мөнгөн оршдос Аудит ХХК  
Захирал: Ц.Таванчулуу  
Утас: 99177464 Цахим хаяг: [tavanchuluu.ts@moaudit.com](mailto:tavanchuluu.ts@moaudit.com)

Улаанбаатар хот  
2022 он

## Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	10
3. Аудитын тайлан.....	12
3.1 Ерөнхий зүйл.....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	13
3.4 Материаллаг байдал .....	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	14
3.8 Аудитын гол асуудал .....	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	15
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
4. Аудитын илрүүлэлт .....	16
4.1 Зөвлөмж.....	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	0

### Товчилсон үгийн жагсаалт

АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

ТУУЛ ГОЛЫН САВ ГАЗРЫН  
ЗАХИРГААНЫ ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б.ОЮУНБОЛД  
ТАНАА

᠒᠐᠒᠒.᠐᠒.᠒5 № 07/366  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын санал дүгнэлт

#### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Туул голын сав газрын захиргааны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Туул голын сав газрын захиргааны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний байгууллагаас цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


#### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>608,794,581.49</b>	<b>610,340,918.49</b>
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	<b>548,800,000.00</b>	<b>548,800,000.00</b>
34600	Урьдчилж гарсан зардал	548,800,000.00	548,800,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>59,994,581.49</b>	<b>61,540,918.49</b>
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>59,994,581.49</b>	<b>61,540,918.49</b>
35410	Бичиг хэргийн материал	3,042,761.00	2,873,814.00
35420	Аж ахуйн материал	52,169,820.49	54,692,104.49
35430	Сэлбэг хэрэгсэл	4,056,000.00	3,935,000.00
35440	Түлш, шатах тослох материал	726,000.00	40,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>251,013,254.56</b>	<b>185,839,581.25</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>251,013,254.56</b>	<b>185,839,581.25</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>250,593,254.56</b>	<b>185,609,581.21</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	162,771,475.19	162,771,475.19
39202	Хуримтлагдсан элэгдэл	(53,630,386.91)	(61,768,960.79)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	102,923,573.78	75,367,573.78
39204	Хуримтлагдсан элэгдэл	(35,552,434.88)	(24,341,030.56)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	190,131,287.80	62,726,800.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(126,422,025.10)	(35,835,071.65)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	24,947,825.00	23,140,025.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(14,845,377.32)	(16,720,546.76)
39217	Ном	269,317.00	269,317.00
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>420,000.00</b>	<b>230,000.04</b>
39301	Программ хангамж	420,000.00	420,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-	(189,999.96)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>859,807,836.05</b>	<b>796,180,499.74</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>859,807,836.05</b>	<b>796,180,499.74</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>859,807,836.05</b>	<b>796,180,499.74</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	346,824.00	346,824.00
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>859,461,012.05</b>	<b>795,833,675.74</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	1,018,282,501.83	859,461,012.05
51220	Тайлант үеийн үр дүн	(158,821,489.78)	(63,627,336.31)
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>859,807,836.05</b>	<b>796,180,499.74</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>526,817,759.78</b>	<b>392,076,000.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>121,257,873.78</b>	-
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>121,257,873.78</b>	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	121,257,873.78	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>405,559,886.00</b>	<b>392,076,000.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>388,365,600.00</b>	<b>371,276,000.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	388,365,600.00	371,276,000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>17,194,286.00</b>	<b>20,800,000.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,014,286.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	10,180,000.00	20,800,000.00
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>685,639,249.56</b>	<b>455,286,669.68</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>685,639,249.56</b>	<b>455,286,669.68</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>395,031,606.52</b>	<b>359,407,071.41</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>240,886,973.58</b>	<b>222,720,338.69</b>
210101	Үндсэн цалин	178,479,111.84	157,350,994.18
210102	Нэмэгдэл	45,579,415.21	49,184,316.51
210103	Унаа хоолны хөнгөлөлт	16,828,446.53	16,185,028.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>31,410,492.38</b>	<b>30,467,219.04</b>
210201	Тэтгэврийн даатгал	21,359,136.54	21,499,278.78
210202	Тэтгэмжийн даатгал	2,512,837.71	2,389,832.03
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,010,273.17	1,777,465.60
210204	Ажилгүйдлийн даатгал	502,566.54	436,422.02
210205	Эрүүл мэндийн даатгал	5,025,678.42	4,364,220.61
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>20,463,474.00</b>	<b>4,690,100.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	10,896,099.00	1,851,300.00
210302	Түлш, халаалт	9,567,375.00	2,838,800.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>18,564,850.00</b>	<b>14,966,769.00</b>
210401	Бичиг хэрэг	2,339,725.00	2,272,115.00
210402	Тээвэр, шатахуун	6,861,500.00	8,938,140.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,259,134.00	2,007,866.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,104,491.00	1,748,648.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>799,300.00</b>	<b>3,854,000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	638,000.00
210604	Урсгал засвар	799,300.00	3,216,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>6,507,500.00</b>	<b>8,022,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	6,507,500.00	8,022,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>22,980,230.00</b>	<b>6,382,238.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	20,000,000.00	3,568,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,160,000.00	2,160,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	115,830.00	204,930.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	258,500.00	110,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	134,400.00	107,808.00

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	311,500.00	231,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>53,418,786.56</b>	<b>68,304,406.68</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,246,500.00	1,457,400.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	52,172,286.56	66,847,006.68
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>290,607,643.04</b>	<b>95,879,598.27</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>12,380,400.00</b>	<b>2,560,100.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	2,560,100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	12,380,400.00	-
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>278,227,243.04</b>	<b>93,319,498.27</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	51,309,857.04	85,519,498.27
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	226,917,386.00	7,800,000.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>(158,821,489.78)</b>	<b>(63,210,669.68)</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>-</b>	<b>416,666.63</b>
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	416,666.63
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>(158,821,489.78)</b>	<b>(63,627,336.31)</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	346,824.00	-	1,018,282,501.83	1,018,629,325.83
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	346,824.00	-	1,018,282,501.83	1,018,629,325.83
9	Тайлант үеийн үр дүн	-	-	(158,821,489.78)	(158,821,489.78)
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	346,824.00	-	859,461,012.05	859,807,836.05
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	346,824.00	-	859,461,012.05	859,807,836.05
19	Тайлант үеийн үр дүн	-	-	(63,627,336.31)	(63,627,336.31)
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	346,824.00	-	795,833,675.74	796,180,499.74

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>650,498,986.00</b>	<b>392,076,000.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>650,498,986.00</b>	<b>392,076,000.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>388,365,600.00</b>	<b>371,276,000.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	388,365,600.00	371,276,000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>262,133,386.00</b>	<b>20,800,000.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	4,022,500.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	247,930,886.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	10,180,000.00	20,800,000.00
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>647,088,986.00</b>	<b>389,986,000.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>647,088,986.00</b>	<b>389,986,000.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>356,481,342.96</b>	<b>294,106,401.73</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>240,886,973.58</b>	<b>222,720,338.69</b>
210101	Үндсэн цалин	178,479,111.84	157,350,994.18
210102	Нэмэгдэл	45,579,415.21	49,184,316.51
210103	Унаа хоолны хөнгөлөлт	16,828,446.53	16,185,028.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>31,410,492.38</b>	<b>30,467,219.04</b>
210201	Тэтгэврийн даатгал	21,359,136.54	21,499,278.78
210202	Тэтгэмжийн даатгал	2,512,837.71	2,389,832.03
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,010,273.17	1,777,465.60
210204	Ажилгүйдлийн даатгал	502,566.54	436,422.02
210205	Эрүүл мэндийн даатгал	5,025,678.42	4,364,220.61
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>20,463,474.00</b>	<b>4,690,100.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	10,896,099.00	1,851,300.00
210302	Түлш, халаалт	9,567,375.00	2,838,800.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>20,552,773.00</b>	<b>15,463,166.00</b>
210401	Бичиг хэрэг	2,760,635.00	1,971,150.00
210402	Тээвэр, шатахуун	10,168,600.00	8,260,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,994,134.00	1,867,866.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,629,404.00	3,364,150.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>6,210,400.00</b>	<b>4,756,199.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	999,000.00	1,540,199.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,150,000.00	-
210604	Урсгал засвар	4,061,400.00	3,216,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>6,507,500.00</b>	<b>8,022,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	6,507,500.00	8,022,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>29,170,230.00</b>	<b>6,529,979.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	26,300,000.00	3,568,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,160,000.00	2,160,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	115,830.00	204,930.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	258,500.00	258,241.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	134,400.00	107,808.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	201,500.00	231,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,279,500.00</b>	<b>1,457,400.00</b>

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,279,500.00	1,457,400.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>290,607,643.04</b>	<b>95,879,598.27</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>12,380,400.00</b>	<b>2,560,100.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	2,560,100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	12,380,400.00	-
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>278,227,243.04</b>	<b>93,319,498.27</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	51,309,857.04	85,519,498.27
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	226,917,386.00	7,800,000.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>3,410,000.00</b>	<b>2,090,000.00</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>3,410,000.00</b>	<b>2,090,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>3,410,000.00</b>	<b>2,090,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>3,410,000.00</b>	<b>2,090,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	3,410,000.00	2,090,000.00
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>(3,410,000.00)</b>	<b>(2,090,000.00)</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>371,276,000.00</b>	<b>285,756,501.73</b>	<b>85,519,498.27</b>	<b>77.0</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>371,276,000.00</b>	<b>285,756,501.73</b>	<b>85,519,498.27</b>	<b>77.0</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>349,534,700.00</b>	<b>283,196,401.73</b>	<b>66,338,298.27</b>	<b>81.0</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>277,233,700.00</b>	<b>222,720,338.69</b>	<b>54,513,361.31</b>	<b>80.3</b>
210101	Үндсэн цалин	203,642,700.00	157,350,994.18	<b>46,291,705.82</b>	<b>77.3</b>
210102	Нэмэгдэл	55,981,900.00	49,184,316.51	<b>6,797,583.49</b>	<b>87.9</b>
210103	Унаа хоолны хөнгөлөлт	17,609,100.00	16,185,028.00	<b>1,424,072.00</b>	<b>91.9</b>
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>37,772,200.00</b>	<b>30,467,219.04</b>	<b>7,304,980.96</b>	<b>80.7</b>
210201	Тэтгэврийн даатгал	26,580,400.00	21,499,278.78	<b>5,081,121.22</b>	<b>80.9</b>
210202	Тэтгэмжийн даатгал	2,797,900.00	2,389,832.03	<b>408,067.97</b>	<b>85.4</b>
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,238,400.00	1,777,465.60	<b>460,934.40</b>	<b>79.4</b>
210204	Ажилгүйдлийн даатгал	559,600.00	436,422.02	<b>123,177.98</b>	<b>78.0</b>
210205	Эрүүл мэндийн даатгал	5,595,900.00	4,364,220.61	<b>1,231,679.39</b>	<b>78.0</b>
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>4,907,200.00</b>	<b>4,690,100.00</b>	<b>217,100.00</b>	<b>95.6</b>
210301	Гэрэл, цахилгаан	2,068,400.00	1,851,300.00	<b>217,100.00</b>	<b>89.5</b>
210302	Түлш, халаалт	2,838,800.00	2,838,800.00	<b>0.00</b>	<b>100.0</b>
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>11,291,400.00</b>	<b>10,379,166.00</b>	<b>912,234.00</b>	<b>91.9</b>
210401	Бичиг хэрэг	1,976,000.00	1,971,150.00	<b>4,850.00</b>	<b>99.8</b>
210402	Тээвэр, шатахуун	3,213,300.00	3,176,000.00	<b>37,300.00</b>	<b>98.8</b>
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,733,700.00	1,867,866.00	<b>865,834.00</b>	<b>68.3</b>
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,368,400.00	3,364,150.00	<b>4,250.00</b>	<b>99.9</b>
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>6,926,900.00</b>	<b>6,846,199.00</b>	<b>80,701.00</b>	<b>98.8</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,674,900.00	3,630,199.00	<b>44,701.00</b>	<b>98.8</b>
210604	Урсгал засвар	3,252,000.00	3,216,000.00	<b>36,000.00</b>	<b>98.9</b>
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>4,853,800.00</b>	<b>1,974,000.00</b>	<b>2,879,800.00</b>	<b>40.7</b>
210702	Дотоод албан томилолт	4,853,800.00	1,974,000.00	<b>2,879,800.00</b>	<b>40.7</b>
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>5,092,100.00</b>	<b>4,661,979.00</b>	<b>430,121.00</b>	<b>91.6</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,840,600.00	1,700,000.00	<b>140,600.00</b>	<b>92.4</b>
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,160,000.00	2,160,000.00	<b>0.00</b>	<b>100.0</b>
210803	Даатгалын үйлчилгээ	385,000.00	204,930.00	<b>180,070.00</b>	<b>53.2</b>
210804	Тээврийн хэрэгслийн татвар	258,500.00	258,241.00	<b>259.00</b>	<b>99.9</b>
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	198,000.00	107,808.00	<b>90,192.00</b>	<b>54.4</b>
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	250,000.00	231,000.00	<b>19,000.00</b>	<b>92.4</b>
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,457,400.00</b>	<b>1,457,400.00</b>	<b>0.00</b>	<b>100.0</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,457,400.00	1,457,400.00	<b>0.00</b>	<b>100.0</b>
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>21,741,300.00</b>	<b>2,560,100.00</b>	<b>19,181,200.00</b>	<b>11.8</b>

<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>21,741,300.00</b>	<b>2,560,100.00</b>	<b>19,181,200.00</b>	<b>11.8</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	2,560,100.00	2,560,100.00	0.00	100.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	19,181,200.00	0	19,181,200.00	0.0
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>371,276,000.00</b>	<b>371,276,000.00</b>	<b>0.00</b>	<b>100.0</b>
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>371,276,000.00</b>	<b>371,276,000.00</b>	<b>0.00</b>	<b>100.0</b>
310001	Улсын төсвөөс санхүүжих	371,276,000.00	371,276,000.00	0.00	100.0
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>47</b>	<b>47</b>		
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1</b>	<b>1</b>		
610001	Төсвийн байгууллага	1	1		
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>23</b>	<b>23</b>		
620001	Удирдах ажилтан	1	1		
620002	Гүйцэтгэх ажилтан	18	18		
620003	Үйлчлэх ажилтан	4	4		
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>23</b>	<b>23</b>		
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	19	19		
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	4	4		

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Туул голын сав газрын захиргааны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад бараа материалын дансанд үндсэн хөрөнгө бүртгэсэн асуудалтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 1 дүгээр сарын 25-наас 2022 оны 2 дугаар сарын 25-ны хооронд Мөнгөн оршдос Аудит ХХК-ийн аудитор Б.Тамир, аудиторын туслах Г.Содбилэг нар гүйцэтгэж, хяналтыг чанарын хяналтын менежер Б.Отгонцэцэг, захирал Ц.Таванчулуу нар хэрэгжүүлсэн.

Туул голын сав газрын захиргааны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Мөнгөн оршдос Аудит ХХК-нд 2022 оны 1 дүгээр сарын 24-ны өдрийн 02/20 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Туул голын сав газрын захиргаа нь Усны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2 дахь заалтын дагуу Байгал орчин, аялал жуулчлалын сайдын 2012 оны А-288 дугаар тушаалаар байгуулагдсан, сав газрын хэмжээнд усны нөөцийг хомсдох, бохирдохоос хамгаалах, боломжит нөөцийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, орон нутгийн болон салбар дундын зохицуулалтыг хангах, усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх үүрэг бүхий Төрийн захиргааны байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаал “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”
- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Туул голын сав газрын захиргааны 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр “нийт зардал”-ыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Бага” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн “нийт зардал”-ын 685,639.2 мянган төгрөгөөс 2.0 хувиар буюу 13,712.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 10,970.2 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Туул голын сав газрын захиргааны 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 63,627.3 мянган төгрөгөөр буюу 7.4 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

	/мянган төгрөг/		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Урьдчилж гарсан тооцоо	548,800.0	548,800.0	-
Бараа материал	59,994.6	61,540.9	1,546.3
Үндсэн хөрөнгө	251,013.2	185,839.6	(65,173.6)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>859,807.8</b>	<b>796,180.5</b>	<b>(63,627.3)</b>
Төрийн өмч	346.8	346.8	-
Хуримтлагдсан үр дүн	859,461.0	795,833.7	(63,627.3)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>859,807.8</b>	<b>796,180.5</b>	<b>(63,627.3)</b>

Дансны үлдэгдэл гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлт байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 185,839.6 мянган төгрөг болж 65,173.6 мянган төгрөгөөр буурсан нь үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал 66,847.0 мянган төгрөг байгаатай холбоотой байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус захиргааны 2021 оны зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 371,276.0 мянган төгрөгөөр төлөвлөж төсвийн төслийг дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 371,276.0 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ. Гүйцэтгэлээр үйл ажиллагааны зардалд 285,756.5 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 85,519.5 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 77 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийг 61,818.4 мянган, хангамж бараа материалын зардлыг 912.2 мянган, байр ашиглалтай холбоотой зардлыг 217.1 мянган, томилолтын зардлыг 2,879.8 мянган, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийг 430.1 мянган, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийг 19,181.2 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

*Хүснэгт-3 Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

*/мянган төгрөг/*

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
1	71404	Усны нөөц, нуур, гол мөрний менежмент	347,694.1	281,496.4	66,197.7	80.9
1.1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	347,694.1	281,496.4	66,197.7	80.9
1.2	80219	Харуул хамгаалалтын зардал	1,840.6	1,700.0	140.1	92.4
1.3	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж	21,741.3	2,560.1	19,181.2	11.8

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд 72 ААН-ээс ус ашиглуулах дүгнэлт гаргуулсны төлбөр 7,200.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлсэн байна.

### 3.8 Аудитын гол асуудал

Туул голын сав газрын захиргааны санхүүгийн тайлангийн аудитад нөлөөлөх гол асуудал байхгүй байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу дараах байдлаар нийцлийн аудитын асуудлыг тайланд тусгасан болно.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Туул голын сав газрын захиргаа нь 2021 онд нийт 384,276.0 мянган төгрөгийн 142 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст бүрэн байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэж байна гэж дүгнэлээ.

### 3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар илэрсэн 10,649.2 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 4 зөвлөмж өгсөн. Үүнд:

1. Татварын тайлангаар цалин, хөдөлмөрийн хөлс, тэдгээртэй адилтгах орлогоос суутгасан урьд оны үлдэгдэл 2.5 мянган төгрөгийн илүү төлөлтийг хэлтэстэй тооцоо нийлж, татварын системийн тооцооллын алдааг залруулсан.
2. Ус ашиглах дүгнэлтийн төлбөр 6,200.0 мянган төгрөгийн орлогоос 100.0 мянган төгрөгийн орлогод цахим төлбөрийн баримтыг шивж олгосон. Үлдэх 6,100.0 мянган төгрөгийн төлбөрийн цахим баримтыг завсрын аудитаар нөхөж олгуулсан.
3. Дотоодоос бараа ажил үйлчилгээ худалдаж авахад 22,045.2 мянган төгрөгийг төлсөн бөгөөд үүний 3,946.7 мянган төгрөгийн зардлын цахим баримтыг нөхөж авч анхан шатны баримтанд хавсаргасан.
4. 2021 оны эхний хагас жилийн тооллогоор 600.0 мянган төгрөгөөр бүртгэлтэй 1 ш мотоцикл тоологдоогүй, тооллогын тайланд тусгагдаагүй байсныг дахин тоолж, ТӨБЗГ-ны 2021 оны А-1/2162 дугаар албан бичгээр Үенч Бодонч Булган голын сав газрын захиргаанд балансаас балансад шилжүүлсэн.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1 албан шаардлага, 2,530.0 мянган төгрөгийн 1 зөвлөмж бүрэн хэрэгжсэн байна.

*Хүснэгт-4* Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	-	1	-	-	-	100.0
Төлбөрийн акт	1	2,530.0	1	2,530.0	-	-	100.0
<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>2,530.0</b>	<b>2</b>	<b>2,530.0</b>	-	-	-

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Санхүүгийн байдлын тайлангийн урьдчилгаа дансны үлдэгдэл 548,800.0 мянган төгрөгийн зарцуулалт, санхүүжилтийн гүйцэтгэл, гэрээний биелэлтийг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## **4. Аудитын илрүүлэлт**

---

Аудитаар алдаа зөрчлийг давтан гаргахгүй талаар 1 зөвлөмж өглөө.

### **4.1 Зөвлөмж**

***Төслийн хөрөнгөөр санхүүжүүлсэн ашиглалтгүй хөрөнгөтэй холбоотой асуудал***

Илрүүлэлт: БОАЖС-ын 2019 оны А/362 дугаар тушаалаар Байгаль орчин уур амьсгалын сангийн Уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийг сааруулах төслөөс 3 ширхэг ариун цэврийн байгууламжийг байгуулсан боловч одоог хүртэл эд хөрөнгийг ашиглагч байгууллагуудад шилжүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хөрөнгийг ашиглагч байгууллагад шилжүүлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Туул голын сав газрын захиргааны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс						
							Залруулга		Албан шаардлага		Зөвлөмж		
							Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо
<b>Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар</b>													
1	Туул голын сав газрын захиргаа	АХГ-2022/02/НА-СТА-ТХН	Тайлант оны бараа материалын дансыг тулган шалгахад бараа материалын /35420/ бүхий 3 ширхэг ариун цэврийн байгууламжийг бүртгэсэн байна.	Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.	1							1	
<b>ДҮН</b>					<b>1</b>	<b>-</b>	<b>0</b>	<b>-</b>	<b>0</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>-</b>	





